МБҮА
МОНГОЛЫН БАРИЛГЫН ҮНДЭСНИЙ АССОЦИАЦИ
SINCE 2009

СУДАЛГААНЫ ТАЙЛАН

Барилга, дэд бүтцийн салбар дахь ажиллах хүчний асуудал: Ази болон Монгол Улс

2025

Цуврал №7
www.mnca.mn

МБҮА
МОНГОЛЫН БАРИЛГЫН ҮНДЭСНИЙ АССОЦИАЦИ
SINCE 2009

СУДАЛГААНЫ ТАЙЛАН

Барилга, дэд бүтцийн салбар дахь ажиллах хүчний асуудал:
Ази болон Монгол Улс

ЦУВРАЛ №7
www.mnca.mn

Улаанбаатар
2025.08

АГУУЛГА

ХУРААНГУЙ 3

I. ӨНӨӨГИЙН БАЙДАЛ 4

1.1 Ази, Номхон далайн бүсийн ерөнхий тойм 4

1.2 Монгол Улсын ерөнхий тойм 7

1.2.1 Барилгын салбарт ажиллагчид 7

1.2.2 Тээвэр, агуулахын үйл ажиллагааны салбарт ажиллагчид 14

1.2.3 Цахилгаан, хий, уур, агааржуулалтын салбар 17

1.2.4 Мэдээлэл, харилцаа холбоо 22

1.2.5 Усан хангамж; бохир ус зайлуулах систем, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа 25

II. АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ЭРЭЛТ, НИЙЛҮҮЛЭЛТ 28

2.1 Эрэлт, нийлүүлэлтийн өнөөгийн байдал 28

Энэ хэсэгт Ази, Номхон далайн бүс нутгийн болон Монгол Улсын барилга, дэд бүтцийн салбарын ажиллах хүчний эрэлт, нийлүүлэлтийн өнөөгийн байдал, ажиллах хүчний хомсдол үүссэн эсэх талаарх мэдээллийг оруулаа. 28

2.1.1 Ази, Номхон далайн бүсийн ерөнхий тойм 28

2.1.2 Монгол Улсын барилга, дэд бүтцийн салбарын ажиллах хүчний эрэлт нийлүүлэлт 29

2.2 Ажиллах хүчний хомсдол 34

2.2.1 Ази, Номхон далайн бүсийн ерөнхий тойм 35

2.2.2 Монгол Улсын ерөнхий тойм 36

III. БОДЛОГЫН ЗӨВЛӨМЖ 42

3.1 Боломж 42

3.2 Бодлогын зөвлөмж 42

1. **Техникийн болон мэргэжлийн сургалтыг бэхжүүлэх:** 42

2. Цалин хөлсийг нэмэгдүүлэх: 42

3. Ажлын нөхцөл, аюулгүй байдал, аюулгүй байдлын стандарт: 42

5. Хөдөлмөр эрхлэлтийн бодлогыг улам боловсронгуй болгох 43

6. Санхүүжилт, дэмжлэг 43

ХАВСРАЛТ 44

АШИГЛАСАН МАТЕРИАЛУУД 46

ХУРААНГУЙ

Барилга, дэд бүтцийн салбарууд нь Ази тивийн эдийн засгийн хөгжлийн суурь тулгуур болдог хэдий ч ажиллах хүчний хомсдол анхаарал хандуулахуйц түвшинд хүрч хямрал тулгараад байна. Азийн улс орнууд, түүний дотор Монгол Улсын барилга, дэд бүтцийн салбар эдийн засгийн өсөлт, хөгжлийн зорилтод нөлөөлөхүйц урьд өмнө байгаагүй ажиллах хүчний хэрэгцээ шаардлага гарч хомсдолд орж байна.

Энэхүү судалгааг бэлтгэхдээ улс орнуудын үндэсний статистикийн байгууллагууд, олон улсын байгууллагууд (Дэлхийн банк, ОУХБ, АХБ)-ын тоон мэдээлэл, салбарын тайлангуудын мэдээллийг эх үүсвэр болгон ашигласан бөгөөд Ази, Номхон далайн бүсийн орнууд, түүний дотор Монгол Улсын барилга, дэд бүтцийн салбарын ажиллах хүчний өнөөгийн байдал, эрэлт, нийлүүлэлт, хомсдолын шалтгаан, үр дагаврыг судалж, шийдэл боломжуудыг тодорхойлоход анхаарлаа хандуулсан болно.

- 2025 он гэхэд Зүүн Өмнөд Азийн бүс нутагт барилгын төслүүдийн өсөн нэмэгдэж буй эрэлтийг хангахын тулд **1.5** сая мэргэжилтэй ажилчин нэмэлтээр шаардлагатай болно.
- Азийн хөгжлийн банкны (АХБ) мэдээлснээр Зүүн өмнөд Азийн бүсэд барилгын ажил жил бүр **7.0** хувиар өсөх төлөвтэй байгаа нь мэргэшсэн ажилчдыг олох, бүрдүүлэхэд сорилт болж байна.
- Зүүн өмнөд Азийн бүс нутгийн барилгын зах зээлийн хэмжээ 2023 онд 2.8 тэрбум америк доллар байсан бол 2029 онд 5.3 тэрбум долларт хүрэхээр байна.
- Монголын барилгын салбар 2024 онд 4.8%-ийн өсөлттэй, 2028 он хүртэл тогтвортой өсөхөөр байгаа хэдий ч ажиллах хүчний томоохон сорилтуудтай тулгарч байна.
- Дэд бүтцийн салбарт 2024 онд 225.9 мянган хүн ажиллаж байгаа бөгөөд 2023 оныхоос 13.2 хувиар буюу 26.4 мянгаар нэмэгдсэн байна.
- 2024 оны жилийн эцсийн байдлаар барилгын салбарт 93.2 мянган хүн, цахилгаан, хий, уур, агааржуулалтын салбарт 23.0 мянга, усан хангамж; бохир ус зайлуулах систем, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагааны салбарт 7.6 мянга, мэдээлэл, холбооны салбарт 21.2 мянга, тээвэр ба агуулахын үйл ажиллагааны салбарт 81.0 мянган ажиллагч ажиллаж байна.
- 2024 онд барилгын салбарт шаардлагатай мэргэжилтэй ажилтан олдоогүйн улмаас төлөвлөсөн ажилтнаа авч чадаагүй буюу ажиллах хүчний хомсдолд өртсөн ажлын байр 5.2 мянга байгаа нь улсын хэмжээнд хомсдолд өртсөн 16.2 мянган ажлын байрны 32.2%-ийг эзэлж байна.
- Хүн ам, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, судалгааны хүрээлэнгийн мэдээллээр, барилгын салбарт жилд дунджаар 13.5 мянган ажиллах хүчний эрэлт бий болж, 4.3 мянган ажиллах хүчний хомсдол бий болж байна.

"2035 он гэхэд барилга, дэд бүтцийн салбарт 302.4 мянган ажиллагч шаардлагатай болно." ("Монгол Улсын хөдөлмөрийн зах зээлийн дунд хугацааны эрэлт, нийлүүлэлтийн таамаглал" судалгааны

I. ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

1.1 Ази, Номхон далайн бүсийн ерөнхий тойм

Барилгын салбар нь олон төрлийн ажил мэргэжлийн ажиллах хүчний шингээлт сайтай чухал ажил олгогч юм. Энэ салбарын зах зээл өргөжиж, ажил эрхлэлт өсөх төлөвтэй байгаа бөгөөд үүнийг дагаад олон тооны ажлын байр нэмэгдэхээр байна. Хөгжиж буй орнуудад дэд бүтцийн хөгжлөөс үүдэн барилгын ажлын байр нэмэгдэж магадгүй. Гэвч зарим өндөр хөгжилтэй орнуудад ажил эрхлэлт буурч байгаа бөгөөд Report Linker-ийн мэдээлснээр, Япон, Их Британи 2023 онд барилгын ажил эрхлэлт буурсан бол Германд бага зэрэг өссөн байна. Энэ хандлагад хөгжингүй эдийн засагт үр ашгийг нэмэгдүүлэх автоматжуулалт зэрэг хүчин зүйлс нөлөөлж байж болзошгүй юм[1].

Ази тивд тээврийн салбарт ажил эрхлэлт мөн асар их бөгөөд тус салбар олон сая хүнийг ажлын байраар хангаж, эдийн засагт ихээхэн хувь нэмэр оруулдаг чухал салбар юм. АХБ-ны Asian Transport Outlook (ATO)-т мэдээлснээр, тус тивд тээврийн салбарт 165 сая гаруй хүн ажилладаг, энэ нь нийт ажил эрхлэлтийн 8 гаруй хувийг эзэлдэг бол дотоодын нийт бүтээгдэхүүний (ДНБ) 6.5 хувийг эзэлж байна[2].

2019 оны байдлаар, дэлхийн эрчим хүч болон холбогдох салбарт 65 сая гаруй хүн ажиллаж байсан нь дэлхийн хэмжээний албан хөдөлмөр эрхлэлтийн бараг 2 хувийг эзэлж байна. Ус, хий, цахилгааны салбар нь Азид, ялангуяа эрчим хүчний дэд бүтэц хурдацтай хөгжиж буй орнуудад сая сая ажлын байр бий болгодог томоохон ажил олгогч юм. Ази, номхон далайн бүс нутгийн хэмжээнд 21.7 сая ажилтан нүүрс, газрын тос, хий, биоэнерги, эрчим хүч үйлдвэрлэл, эрчим хүчний сүлжээнд ажиллаж байна. Эдгээрийн 50.2 хувь буюу 10.9 сая хүн БНХАУ-д, 24.4 хувь буюу 5.3 сая нь БНЭУ-д нүүрс, газрын тос, хий, биоэнерги, эрчим хүч үйлдвэрлэл, эрчим хүчний сүлжээнд ажиллаж байна[3].

Харилцаа холбооны үйлчилгээ нь дэлхийн эдийн засагт чухал үүрэг гүйцэтгэдэг. Дэлхийн харилцаа холбооны үйлчилгээний зах зээлийн хэмжээ 2022 онд 1,805.61 тэрбум ам.долларт хүрсэн бөгөөд 2023-2030 он хүртэл жил бүрийн нийлмэл өсөлтийн дундаж хурд 6.2%-иар тэлэх төлөвтэй байна. Захидал харилцаа, шуудангийн үйлчилгээнээс олсон орлого мэдэгдэхүйц буурч, 2005 онд харилцаа холбооны орлогын 50-аас дээш хувийг эзэлдэг байснаа 2021 онд 34% бол буурсан бол илгээмж, ложистикийн орлого өсч 2005 оны 11% байснаа 2021 онд 32-оос дээш хувьд хүрчээ.

2003-2022 оны хооронд шуудангийн болон харилцаа холбооны үйлчилгээний ажил эрхлэлт нь дундаас доогуур болон дундаас дээш орлоготой орнуудын 70 гаруй хувьд, түүний дотор илгээмж, ложистикийн ажлын байранд өссөн байна.

Ази, Номхон далайн бүсийн хэмжээнд 2023 оны байдлаар харилцаа холбооны салбарт 12.6 сая хүн ажиллаж байгаа бөгөөд хүйсийн хувьд 74.1 хувь нь буюу 9.3 сая нь эрэгтэйчүүд, 25.9 хувь нь буюу 3.3 сая нь эмэгтэйчүүд байна[4].

---

[1] www.reportlinker.com

[2] www.adb.org; www.ilo.org

[3] https://www.iea.org/reports/world-energy-employment-2022

[4] https://www.ilo.org/topics-and-sectors/industries-and-sectors/postal-and-telecommunications-services-sector

Хүснэгт 1. Барилга, дэд бүтцийн салбарт ажиллагчид, хүйсээр, АХС явагдсан оноор, улсаар

Улс	Барилга			Цахилгаан, уур ус, хий			Тээвэр			Холбоо		
	Бүгд	Үүнээс:		Бүгд	Үүнээс:		Бүгд	Үүнээс:		Бүгд	Үүнээс:	
		Эрэгтэй	Эмэгтэй		Эрэгтэй	Эмэгтэй		Эрэгтэй	Эмэгтэй		Эрэгтэй	Эмэгтэй
Афганистан (2021)	915.4	902.7	12.6	25.9	25.9		401.6	400.2				
Австрали (2024)	1333.1	1150.6	182.5	198.128	143.704	54.4	610.0	478.3	131.7	185.2	136.3	48.9
Бангладеш (2023)	3847.1	3767.9	78.7	140.216	129.761	10.456	5824.0	5779.9	43.6	159.2	152.5	6.8
Бутан (2024)	23.7	22.0	1.6	7.009	5.556	1.453	13.5	12.9	0.6	1.4	1.0	0.4
Фижи (2024)	18.8	16.4	2.4	3.1	2.6	0.5	15.6	12.6	3.0	1.8	1.0	0.8
Индонез (2023)	8928.8	8778.6	150.2	870.7	698.7	172.0	5159.7	4922.0	237.7	1303.1	973.7	329.4
Энэтхэг (2024)	60557.7	55136.1	5421.5	2950.6	2596.6	354.0	22025.2	21712.2	313.0	1251.4	1144.2	107.2
Япон (2022)	4759.3	3913.6	845.7	995.5	774.2	221.2	3326.7	2598.1	728.6	599.2	397.1	202.1
Кампуч (2023)	893.8	806.8	87.0	36.2	26.3	10.0	475.9	438.7	37.2	10.6	8.1	2.5
БНСУ (2019)	1960.1	1785.7	174.4	259.1	206.6	52.6	1245.6	1135.4	110.2	278.9	210.3	68.6
Лаос (2022)	121.9	113.4	8.5	3.1	2.6		58.8	55.3	3.5	3.1	2.3	
Шри ланка (2022)	612.0	600.2	11.8	78.4	58.3	20.1	455.3	443.1	12.2	40.8	29.5	11.3
Монгол (2023)	82.1	68.9	13.2	30.8	20.6	10.2	65.4	56.6	8.9	10.1	6.2	3.9
Непал (2017)	977.6	866.6	111.0	76.5	61.0	15.5	317.2	310.4	6.9	29.8	25.5	4.2
Пакистан (2021)	5906.0	5851.2	54.8	396.4	385.7	10.7	3532.7	3529.5	3.2	151.6	147.7	3.8
Филиппин (2023)	2199.5	2150.1	49.4	74.8	60.5	14.3	1551.6	1489.7	61.9	232.7	187.1	45.7
Сингапур (2024)	102.9	72.7	30.1	18.4	13.1	5.3	168.3	129.3	39.1	32.5	22.6	9.9
Тайланд (2024)	2303.8	1945.2	358.6	193.1	143.5	49.6	1408.6	1158.7	249.9	236.4	172.2	64.2
Вьетнам (2023)	4728.6	4242.9	485.7	301.2	207.5	93.7	1789.4	1650.2	139.2	271.8	177.5	94.3
БНХАУ (2022)	51840.2	-	-	19200.0	-	-	-	-	-	740410.0	-	-

Эх үүсвэр: www.ilo.org – LFS data

БАРИЛГЫН САЛБАРЫН АЖИЛЛАГЧДЫН ТОО, ДУНДАЖ ЦАЛИН, ХӨДӨЛМӨРИЙН БҮТЭЭМЖ

2024 он

БАРИЛГЫН САЛБАРЫН АЖИЛЛАГЧДЫН ТОО

НИЙТ АЖИЛЛАГЧИД, мянган хүн

93.2



АЖИЛЛАГЧДЫН ДҮНД ЭЗЛЭХ ХУВЬ

6.9

ДУНДАЖ ЦАЛИН

УЛСЫН ДУНДАЖ ЦАЛИН, мянган төгрөг

2 332.4



БАРИЛГЫН САЛБАРЫН АЖИЛЛАГЧДЫН ДУНДАЖ ЦАЛИН, мянган төгрөг

2 166.0

БАРИЛГЫН САЛБАРЫН АЖИЛЛАГЧДЫН ХӨДӨЛМӨРИЙН БҮТЭЭМЖ

ХӨДӨЛМӨРИЙН БҮТЭЭМЖ, улсын хэмжээнд, сая төгрөг

22.6



ХӨДӨЛМӨРИЙН БҮТЭЭМЖ, барилгын салбар, сая төгрөг

11.0

БАРИЛГЫН САЛБАРЫН ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ОСОЛ

НИЙТ ОСОЛДОГЧИД

67



ҮҮНЭЭС: ЭМЭГТЭЙ

5

Эх үүсвэр:www.1212.mn

1.2 Монгол Улсын ерөнхий тойм

Энэ хэсэгт Монгол Улсын барилга, дэд бүтцийн салбарын ажил эрхлэлтийн өнөөгийн төлөв байдлыг харуулсан мэдээллийг багтаасан бөгөөд Үндэсний статистикийн хорооноос гаргасан Албан ёсны статистик мэдээлэл болон төрийн захиргааны байгууллагуудаас гаргасан захиргааны мэдээллийг эх сурвалж болгон ашиглалаа.


Улсын хэмжээнд 2024 оны эцэст 1.4 сая хүн эдийн засгийн бүхий л салбарт албан хөдөлмөр эрхэлж байгаагийн 6.9 хувь нь буюу 93.2 мянга нь барилгын салбарт ажиллаж байна.

1.2.1 Барилгын салбарт ажиллагчид

Улсын хэмжээнд 15 ба түүнээс дээш насны ажиллагчдын тоо 2024 оны байдлаар 1355.7 мянга байгаагийн 93.2 (6.9%) мянга нь барилгын салбарт ажиллаж байна.

Барилгын салбарын ажиллагчдын тоо өмнөх оноос 11.1 (13.5%) мянгаар өсчээ. Салбарын ажиллагчдын 16.1 (17.3%) мянган нь эмэгтэй, 77.0 (82.7%) мянган нь эрэгтэй байна.


Зураг 1. Барилгын салбарт ажиллагчдын тоо, хүйсээр, жил бүрийн эцэст



Нийт ажиллагчдын 44.1 хувь нь 15-34 насны, 49.6 хувь нь 35-54 насныхан байна. Ажиллагчдын дунд 35-54 насныхан зонхилсон хэвээр байна. Эрэгтэй ажиллагчдын дунд 35-39 насныхан олонх байгаа бол эмэгтэй ажиллагчдын хувьд 25-29 насныхан дийлэнх болж байна. Түүнчлэн 2024 оны эцэст барилгын салбарын ажиллагчдын дунд 65-69 насныхан 2023 онынхоос 2.9 дахин, 70 болон түүнээс дээш насны ажиллагчид 2 дахин буурсан бол 40-44 насны ажиллагчид 1.6 дахин, 15-19 насныхан 1.5 дахин нэмэгдсэн байна.

Ажиллагчдын насны бүтцэд гарсан өөрчлөлт хүйсээр ялгаатай байна, тухайлбал, эрэгтэй ажиллагчид 11.9 хувиар нэмэгдсэний дотор 65-69 насныхан 2.4 дахин, 40-44 насныхан 1.4 дахин, 15-19 болон 20-24 насныхан тус бүр 1.2 дахин нэмэгдсэн бол эмэгтэй ажиллагчид 22.0 хувиар өссөний дотор 15-19 насныхан 11.1 дахин, 55-59 насныхан 4.3 дахин, 40-44 насны эмэгтэйчүүд 2.4 дахин нэмэгдсэн байна.


Зураг 2. Барилгын салбарт ажиллагчдын тоо, насны бүлэг, хүйсээр, 2024



Барилгын ажиллагчдын хүйсийн харьцааг тооцож үзвэл, 100 эмэгтэй ажиллагч тутамд 478 эрэгтэй ажиллагч ногдож байгаа нь барилгын ажлын онцлогоос хамааран эрэгтэйчүүд зонхилон ажилладгийг харуулж байна.


Барилгын салбарын ажиллагчдыг газар зүйн байршлаар авч үзвэл, ажиллагчдын 77.2 хувь нь Улаанбаатар хотод, 7.3 хувь нь төвийн бүсэд, үлдсэн 15.6 хувь нь Баруун, Хангайн болон Зүүн бүсэд ажиллаж байна.

Газрын зураг 1. Барилгын салбарт ажиллагчдын тоо, аймаг, нийслэлийн тархалтаар, 2024




Барилгын салбарт ажиллагчдыг хөдөлмөр эрхлэлтийн 57.2 хувь нь буюу 53.3 мянга нь цалин хөлстэй түр ажиллагч байна.

Зураг 3. Барилгын салбарт ажиллагчдын тоо, хөдөлмөр эрхлэлтийн статусаар, 2024




Ажил мэргэжлээр нь харвал, барилгын салбарын нийт ажиллагчдын 51.9 хувь нь үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил, үйлчилгээний ажил эрхлэгчид буюу барилгын ажиллагчид эзэлж байна.

Зураг 4. Барилгын салбарт ажиллагчдын тоо, ажил мэргэжлээр, 2024




Барилгын салбарт 2024 онд 37.9 мянган хүн албан бус хөдөлмөр эрхэлж байсан бөгөөд тэдний 82.3 хувь нь эрэгтэйчүүд, 17.7 хувь нь эмэгтэйчүүд байна. Тус салбарт албан бус хөдөлмөр эрхлэгчид 2023 оноос 6.9 хувиар нэмэгдсэний дотор эрэгтэйчүүд 0.9 хувиар, эмэгтэйчүүд 1.5 дахин нэмэгдсэн байна.

Зураг 5. Барилгын салбарт албан бус хөдөлмөр эрхлэгчид, хүйсээр, жил бүрийн эцэст




Барилгын салбарт албан бус хөдөлмөр эрхлэгчдийн дийлэнх нь Улаанбаатар хотод ажиллаж байна. Аймгуудаас Баруун бүсийн аймгуудад 2.9 мянган хүн барилгын салбарт албан бус хөдөлмөр эрхэлж байна.

Газрын зураг 2. Барилгын салбарт албан бус хөдөлмөр эрхлэгчид, аймаг, нийслэлийн тархалтаар, 2024




2024 онд 892 хүн гадаад улсад хөдөлмөрийн гэрээгээр ажиллахаар зуучлагдсан бөгөөд тэдгээрийн 27 нь барилгын ажилд зуучлагдсан нь 2023 оныхоос 1.9 дахин нэмэгдсэн байна. Гадаад зуучлагдсан иргэдийн 80.9 хувь нь БНСУ-д, 19.1 хувь нь Япон улсад ажиллахаар явсан байна.

Зураг 6. Гадаад улсад хөдөлмөрийн гэрээгээр ажиллахаар зуучлагдсан хүний тоо, жил бүрийн эцэст



Хөдөлмөрийн гэрээгээр манай улсад хөдөлмөр эрхэлж байгаа гадаадын иргэдийн 9.9 хувь нь барилгын салбарт ажиллаж байгаа бөгөөд 2024 оны 2, 3 дугаар улиралд 7.0 мянган гадаадын иргэн тус салбарт ажилласан нь барилгын ажлын онцлогтой холбоотой юм. Эдгээр хүмүүсийн 96.8 хувь нь эрэгтэйчүүд байна.


Зураг 7. Барилгын салбарт хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж байгаа гадаадын иргэдийн тоо, улирал бүрийн эцэст



ТЭЭВРИЙН САЛБАРЫН АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГА



АЖИЛЛАГЧИД, мянган хүн




ТЭЭВРИЙН ОРЛОГО, төгрөг



ТЭЭСЭН АЧАА, сая тонн



ЗОРЧИГЧИД, сая хүн



БҮХ ТӨРЛИЙН ТЭЭВРИЙН ХЭРЭГСЭЛ

Авто замын бүртгэлтэй тээврийн хэрэгсэл, мянган ширхэг	1 339.0
Төмөр замын хөдлөх бүрэлдэхүүн	7 692
Агаарын хөлөг	36
Хөлөг онгоц	233

Эх үүсвэр: www.1212.mn






1.2.2 Тээвэр, агуулахын үйл ажиллагааны салбарт ажиллагчид

Манай улсын нийт ажиллагчид 2024 оны жилийн эцсийн байдлаар 1.4 саяд хүрч, үүний 81.0 (6.0%) мянга нь тээвэр, агуулахын салбарт ажиллаж байна. Тээвэр, агуулахын салбарт ажиллагчид өмнөх оноос 14.3 (21.4%) мянган хүнээр өсжээ. Нийт ажиллагчдын 86.7 хувь нь эрэгтэйчүүд байна.

Зураг 8. Тээврийн салбарт ажиллагчдын тоо, хүйсээр, жил бүрийн эцэст




Нийт ажиллагчдын 69.7 хувийг 30-49 насныхан эзэлж байгаагийн дотор 19,4 хувь нь 40-44 насны, 17.8 хувь нь 30-34 насныхан байна. Насны бүтцийг хүйсээр харвал, эрэгтэй , эмэгтэй ажиллагчдын дунд мөн 30-49 насныхан зонхилж байгаа бөгөөд эрэгтэйчүүдийн хувьд 30-34, 40-44 насныхан олонх байгаа бол эмэгтэй ажиллагчдын хувьд 40-49 насныхан дийлэнх буюу арван эмэгтэй ажиллагчдын 5 нь энэ насны бүлгийн ажиллагчид байна. Барилгын салбартай харьцуулахад, 70 ба түүнээс дээш насны ажиллагч байхгүй, 65 ба түүнээс дээш насны эмэгтэй ажиллагч байхгүй байна.

Түүнчлэн 2024 оны эцэст тээвэр, агуулахын салбарын ажиллагчдын дунд 65-69 насныхан 2023 оныхоос 2.8 дахин, 30-34 насныхан 1.6 дахин, 60-64 насныхан 1.5 дахин нэмэгдсэн бол 15-19 насныхан 5.9 дахин, 20-24 насны залуус 12.3 хувиар буурсан байна.

Ажиллагчдын насны бүтцэд гарсан өөрчлөлт хүйсээр ялгаатай байна, тухайлбал, эрэгтэй ажиллагчид 23.1 хувиар нэмэгдсэний дотор 65-69 насныхан 2.8 дахин, 30-34 насныхан 1.6 дахин, 60-64 насныхан 1.5 дахин, 25-29 насныхан 1.4 дахин нэмэгдсэн бол эмэгтэй ажиллагчид 11.5 хувиар өссөний дотор 45-49 насныхан 3.5 дахин, 40-44 насныхан 1.7 дахин, 30-34 насныхан 1.2 дахин нэмэгдсэн бол 25-29 насныхан 2.5 дахин, 55-59 насны эмэгтэйчүүд 1.6 дахин буурсан байна.


Тээвэр, агуулахын салбарын ажиллагчдын хүйсийн харьцааг авч үзвэл, 100 эмэгтэй ажиллагчдад 655 эрэгтэй ажилтан ногдож байна.

Зураг 9. Тээвэр, агуулахын салбарт ажиллагчдын тоо, насны бүлэг, хүйсээр, 2024




Тээвэр, агуулахын салбарын ажиллагчдыг газар зүйн байршлаар авч үзвэл, ажиллагчдын 77.2 хувь нь Улаанбаатар хотод, 7.3 хувь нь төвийн бүсэд, үлдсэн 15.6 хувь нь Баруун, Хангайн болон Зүүн бүсэд ажиллаж байна. Ажиллагчдын тоог аймаг, нийслэлээр авч үзвэл, 54.8 (67.7%) мянга нь Улаанбаатар хот, 5.3 (6.5%) мянга нь Дорноговь, 3.1 (3.8%) мянга нь Өмнөговь, 2.5 (3.0%) мянга нь Ховд, 2.3 (2.8%) мянга нь Баян-Өлгий, 2.0 (2.4%) мянга нь Дархан-Уул, 1.4 (1.7%) мянга нь Дорнод, 1.3 (1.6%) мянга нь Архангай, 1.2 (1.5%) мянга нь Хөвсгөл, 1.0 (1.2%) мянга нь Сэлэнгэ аймагт ногдож байна.

Газрын зураг 3. Тээвэр, агуулахын салбарт ажиллагчдын тоо, аймаг, нийслэлийн тархалтаар, 2024




Тээвэр, агуулахын салбарт 2024 онд 31.7 мянган хүн албан бус хөдөлмөр эрхэлж байсан бөгөөд тэдний 94.1 хувь нь эрэгтэйчүүд, 5.9 хувь нь эмэгтэйчүүд байна. Тус салбарт албан бус хөдөлмөр эрхлэгчид 2023 оноос 5.3 мянгаар нэмэгдсэний дотор эрэгтэйчүүд 4,0 мянгаар, эмэгтэйчүүд 1.3 мянгаар тус тус нэмэгдсэн байна.

Зураг 10. Тээвэр, агуулахын салбарт албан бус хөдөлмөр эрхлэгчид, хүйсээр, жил бүрийн эцэст



Тээвэр, агуулахын салбарт албан бус хөдөлмөр эрхлэгчдийн дийлэнх нь буюу 78.5 хувь нь Улаанбаатар хотод ажиллаж байна. Аймгуудаас Баруун бүсийн аймгуудад 3.7 мянган хүн тээвэр, агуулахын салбарт албан бус хөдөлмөр эрхэлж байна.


Газрын зураг 4. Тээвэр, агуулахын салбарт албан бус хөдөлмөр эрхлэгчид, аймаг, нийслэлийн тархалтаар, 2024



2024 онд 892 хүн гадаад улсад хөдөлмөрийн гэрээгээр ажиллахаар зуучлагдсан бөгөөд тэдгээрээс тээврийн ажилд зуучлагдсан хүн байхгүй байна.

Хөдөлмөрийн гэрээгээр манай улсад хөдөлмөр эрхэлж байгаа гадаадын иргэдийн 33.4 хувь нь тээвэр, агуулахын салбарт ажиллаж байгаа бөгөөд 2024 оны 2, 3 дугаар улиралд 1.6 мянган гадаадын иргэн тус салбарт ажилласан байна. Эдгээр хүмүүсийн 95.9 хувь нь эрэгтэйчүүд байна.


Зураг 11. Тээвэр, агуулахын салбарт хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж байгаа гадаадын иргэдийн тоо, улирал бүрийн эцэст



1.2.3 Цахилгаан, хий, уур, агааржуулалтын салбар

Манай улсын нийт ажиллагчдын 1.7 хувь буюу 23.0 мянга нь цахилгаан, хий, уур, агааржуулалтын салбарт ажиллаж байна. Цахилгаан, хий, уур, агааржуулалтын салбарт ажиллагчид өмнөх оноос 14.6 хувь (2.9 мянга)-аар өсжээ. Нийт ажиллагчдын 76.5 хувь нь эрэгтэйчүүд байна.

Зураг 12. Цахилгаан, хий, уур, агааржуулалтын салбарт ажиллагчдын тоо, хүйсээр, жил бүрийн эцэст




Нийт ажиллагчдын 85.7 хувийг 25-54 насныхан эзэлж байгаагийн дотор 19.9 хувь нь 35-39 насны, 16.4 хувь нь 45-49 насныхан байна. Насны бүтцийг хүйсээр харвал, эрэгтэй, эмэгтэй ажиллагчдын дунд мөн 30-49 насныхан зонхилж байгаа бөгөөд эрэгтэйчүүдийн хувьд 25-29, 35-39, 45-49 насныхан олонх байгаа бол эмэгтэй ажиллагчдын хувьд 30-39 насныхан дийлэнх буюу арван эмэгтэй ажиллагчдын 4 нь энэ насны бүлгийн ажиллагчид байна. Ажиллагчдын дунд, 65 ба түүнээс дээш насны эрэгтэй, 15-19, 70 ба түүнээс дээш насны эмэгтэй ажиллагч байхгүй байна.

Түүнчлэн 2024 оны эцэст цахилгаан, хий, уур, агааржуулалтын салбарын ажиллагчдын дунд 15-19 насныхан 2023 оныхоос 20 дахин, 55-59 насныхан 6.3 дахин, 60-64 насныхан 2.1, 25-29, 50-54 насныхан тус бүр 1.3 дахин нэмэгдсэн бол 40-44 насныхан 1.7 дахин, 20-24 насны залуус 1.3 хувиар тус тус буурсан байна.

Ажиллагчдын насны бүтцэд гарсан өөрчлөлт хүйсээр ялгаатай байна, тухайлбал, эрэгтэй ажиллагчид 18.3 хувиар нэмэгдсэний дотор 15-19 насныхан 20 дахин, 55-59 насныхан 6.2 дахин, 60-64 насныхан 2.1 дахин нэмэгдсэн бол эмэгтэй ажиллагчид 4.2 хувиар өссөний дотор 50-54 насныхан 5.1 дахин, 30-34 насныхан 2.7 дахин, 20-24 насныхан 1.3 дахин нэмэгдсэн бол 40-44 насныхан 2.7 дахин, 45-49 насны эмэгтэйчүүд 2.3 дахин буурсан байна. Мөн 2023 онд энэ салбарт 55-59, 65-69 насны эмэгтэй ажиллагч байхгүй байсан бол 2024 онд 55-59 насны 29, 65-69 насны 443 эмэгтэй ажиллагч ажиллаж байна.

Цахилгаан, хий, уур, агааржуулалтын салбарын ажиллагчдын хүйсийн харьцааг авч үзвэл, 100 эмэгтэй ажиллагчдад 326 эрэгтэй ажилтан ногдож байна.


Зураг 13. Цахилгаан, хий, уур, агааржуулалтын салбарт ажиллагчдын тоо, насны бүлэг, хүйсээр, 2024



Цахилгаан, хий, уур, агааржуулалтын салбарын ажиллагчдыг газар зүйн байршлаар авч үзвэл, ажиллагчдын 77.2 хувь нь Улаанбаатар хотод, 7.3 хувь нь төвийн бүсэд, үлдсэн 15.6 хувь нь Баруун, Хангайн болон Зүүн бүсэд ажиллаж байна.


Ажиллагчдын тоог аймаг, нийслэлээр авч үзвэл, 54.8 (67.7%) мянга нь Улаанбаатар хот, 5.3 (6.5%) мянга нь Дорноговь, 3.1 (3.8%) мянга нь Өмнөговь, 2.5 (3.0%) мянга нь Ховд, 2.3 (2.8%) мянга нь Баян-Өлгий, 2.0 (2.4%) мянга нь Дархан-Уул, 1.4 (1.7%) мянга нь Дорнод, 1.3 (1.6%) мянга нь Архангай, 1.2 (1.5%) мянга нь Хөвсгөл, 1.0 (1.2%) мянга нь Сэлэнгэ аймагт ногдож байна.

Газрын зураг 5. Цахилгаан, хий, уур, агааржуулалтын салбарт ажиллагчдын тоо, аймаг, нийслэлийн тархалтаар, 2024




Цахилгаан, хий, уур, агааржуулалтын салбарт 2024 онд 31.7 мянган хүн албан бус хөдөлмөр эрхэлж байсан бөгөөд тэдний 94.1 хувь нь эрэгтэйчүүд, 5.9 хувь нь эмэгтэйчүүд байна. Тус салбарт албан бус хөдөлмөр эрхлэгчид 2023 оноос 5.3 мянгаар нэмэгдсэний дотор эрэгтэйчүүд 4,0 мянгаар, эмэгтэйчүүд 1.3 мянгаар тус тус нэмэгдсэн байна.

Зураг 14. Цахилгаан, хий, уур, агааржуулалтын салбарт албан бус хөдөлмөр эрхлэгчид, хүйсээр, жил бүрийн эцэст



Цахилгаан, хий, уур, агааржуулалтын салбарт албан бус хөдөлмөр эрхлэгчдийн дийлэнх нь буюу Төвийн бүсэд ажиллаж байна. Хангайн бүсийн аймгуудад 30 хүн энэ салбарт албан бус хөдөлмөр эрхэлж байна.


Газрын зураг 6. Тээвэр, агуулахын салбарт албан бус хөдөлмөр эрхлэгчид, бүсээр, 2024



2024 онд 892 хүн гадаад улсад хөдөлмөрийн гэрээгээр ажиллахаар зуучлагдсан бөгөөд тэдгээрээс цахилгаан, хий, уур, агааржуулалтын ажилд зуучлагдсан хүн байхгүй байна.

Хөдөлмөрийн гэрээгээр манай улсад хөдөлмөр эрхэлж байгаа гадаадын иргэдийн 5.5 хувь нь цахилгаан, хий, уур, агааржуулалтын салбарт ажиллаж байгаа бөгөөд 2024 оны 2, 3 дугаар улиралд 2.0 мянган гадаадын иргэн тус салбарт ажилласан байна. Эдгээр гадаад ажиллагчдын 96.7 хувь нь эрэгтэйчүүд байна.

Зураг 15. Цахилгаан, хий, уур, агааржуулалтын салбарт хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж байгаа гадаадын иргэдийн тоо, улирал бүрийн эцэст




МЭДЭЭЛЭЛ, ХАРИЛЦАА ХОЛБОО

МЭДЭЭЛЭЛ, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЧИГЛЭЛЭЭР ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭГЧ АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГА

3.0 мянга

НИЙТ ОРЛОГО, их наяд төгрөг




АЖИЛЛАГЧИД, мянган хүн



ТӨСӨВТ ТӨВЛӨРҮҮЛСЭН ОРЛОГО, их тэрбум төгрөг



АЖИЛЛАГЧДЫН ЦАЛИН, сая төгрөг



МЭДЭЭЛЭЛ, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ САЛБАРЫН ХЭРЭГЛЭГЧ



Эх үүсвэр: www.1212.mn

1.2.4 Мэдээлэл, харилцаа холбоо

Улсын хэмжээнд 2024 оны байдлаар 1.4 сая ажиллагчид байгаагийн 21.2 (1.6%) мянга нь мэдээлэл, харилцаа холбооны салбарт ажиллаж байна. Мэдээлэл, харилцаа холбооны салбарт ажиллагчдын тоо өмнөх оноос 1.3 (6.4%) мянгаар өссөн байна.

Хүснэгт 2. Мэдээлэл, харилцаа холбооны салбарын ажиллагчид, жил бүрийн эцэст


	2020	2021	2022	2023	2024
Бүгд	17507	17739	20057	19887	21152
Эрэгтэй	10176	11470	10898	13686	11464
Эмэгтэй	7331	6269	9159	6202	9688

Нийт ажиллагчдын 83.5 хувийг 20-39 насныхан эзэлж байгаагийн дотор 28.4 хувь нь 25-29 насны, 25.7 хувь нь 30-34 насныхан байна. Насны бүтцийг хүйсээр харвал, эрэгтэй, эмэгтэй ажиллагчдын дунд мөн 20-39 насныхан зонхилж байгаа бөгөөд эрэгтэй ажиллагчдын 53.6 хувь нь 25-34 насныхан, эмэгтэй ажиллагчдын мөн 54.6 хувь нь 25-34 насны бүлгийн ажиллагчид байна. Ажиллагчдын дунд, 15-19, 55-59, 65-69 насны эрэгтэй, 60 ба түүнээс дээш насны эмэгтэй ажиллагч байхгүй байна. Түүнчлэн 2024 оны эцэст мэдээлэл, харилцаа холбооны салбарын ажиллагчдын дунд 45-49 насныхан 2023 оныхоос 2.8 дахин, 35-39 насныхан 1.4 дахин нэмэгдсэн бол 55-59 насныхан 6.0 дахин, 60-64 насны залуус 2.8 дахин буурсан байна.

Ажиллагчдын насны бүтцэд гарсан өөрчлөлт хүйсээр ялгаатай байна, тухайлбал, эрэгтэй ажиллагчид 16.2 хувиар буурсны дотор 40-44 насныхан 1.8 дахин, 25-29 насныхан 1.6 дахин буурч, 45-49 2.0 дахин, 50-54 насныхан 1.5 дахин нэмэгдсэн бол эмэгтэй ажиллагчид 56.2 хувиар өссөний дотор 50-54 насныхан 5.1 дахин, 30-34 насныхан 2.7 дахин, 20-24 насныхан 1.3 дахин нэмэгдсэн бол 40-44 насныхан 2.7 дахин, 45-49 насны эмэгтэйчүүд 2.3 дахин буурсан байна. Мөн 2023 онд энэ салбарт 55-59, 65-69 насны эмэгтэй ажиллагч байхгүй байсан бол 2024 онд 55-59 насны 29, 65-69 насны 443 эмэгтэй ажиллагч ажиллаж байна.

Мэдээлэл, харилцаа холбооны салбарын ажиллагчдын хүйсийн харьцааг авч үзвэл, 100 эмэгтэй ажиллагчдад 326 эрэгтэй ажилтан ногдож байна.

Зураг 16. Мэдээлэл, холбооны салбарт ажиллагчдын тоо, насны бүлэг, хүйсээр, 2024



Мэдээлэл, харилцаа холбооны салбарын ажиллагчдыг газар зүйн байршлаар авч үзвэл, ажиллагчдын 72.2 хувь нь Улаанбаатар хотод, 11.2 хувь нь төвийн бүсэд, үлдсэн 16.6 хувь нь Баруун, Хангайн болон Зүүн бүсэд ажиллаж байна. Ажиллагчдын тоог аймаг, нийслэлээр авч үзвэл, 11794 нь Өвөрхангай, 697 нь Сэлэнгэ, 555 нь Хөвсгөл, 405 нь Дорноговь аймагт ажиллаж байна.


Газрын зураг 7. Мэдээлэл, харилцаа холбооны салбарт ажиллагчид, аймаг, нийслэлээр, 2024



Мэдээлэл, холбооны салбарт 2024 онд 31.7 мянган хүн албан бус хөдөлмөр эрхэлж байсан бөгөөд тэдний 94.1 хувь нь эрэгтэйчүүд, 5.9 хувь нь эмэгтэйчүүд байна.


Тус салбарт албан бус хөдөлмөр эрхлэгчид 2023 оноос 5.3 мянгаар нэмэгдсэний дотор эрэгтэйчүүд 4,0 мянгаар, эмэгтэйчүүд 1.3 мянгаар тус тус нэмэгдсэн байна.

Зураг 17. Мэдээлэл, холбооны салбарт албан бус хөдөлмөр эрхлэгчид, хүйсээр, жил бүрийн эцэст




Мэдээлэл, холбооны салбарт албан бус хөдөлмөр эрхлэгчдийн дийлэнх нь буюу Төвийн бүсэд ажиллаж байна. Хангайн бүсийн аймгуудад 30 хүн энэ салбарт албан бус хөдөлмөр эрхэлж байна.

Газрын зураг 8. Мэдээлэл, харилцаа холбооны салбарт албан бус хөдөлмөр эрхлэгчид, бүсээр, 2024



2024 онд гадаад улсад хөдөлмөрийн гэрээгээр ажиллахаар зуучлагдсан хүмүүсээс мэдээлэл, холбооны ажилд зуучлагдсан хүн байхгүй байна. Хөдөлмөрийн гэрээгээр манай улсын мэдээлэл, холбооны салбарт 2024 онд 172 гадаадын иргэн ажилласан байна. Эдгээр гадаад ажиллагчдын 80.8 хувь нь эрэгтэйчүүд байна.

Зураг 18. Мэдээлэл, холбооны салбарт хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж байгаа гадаадын иргэдийн тоо, улирал бүрийн эцэст



1.2.5 Усан хангамж; бохир ус зайлуулах систем, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа

Улсын хэмжээнд 2024 оны байдлаар 7.6 мянган хүн нь усан хангамж, бохир ус зайлуулах систем, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа салбарт ажиллаж байгаа нь өмнөх оноос 3.2 (29.6%) мянгаар буурсан байна.

Хүснэгт 3. Усан хангамж, бохир ус зайлуулах систем, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа салбарын ажиллагчид, жил бүрийн эцэст

	2020	2021	2022	2023	2024
Бүгд	8099	7875	7027	10726	7550
Эрэгтэй	4045	3624	3822	5677	2773
Эмэгтэй	4054	4251	3204	5050	4777

Нийт ажиллагчдын 58.9 хувийг 30-39, 50-54 насныхан эзэлж байгаагийн дотор 22.8 хувь нь 50-54 насны, 21.2 хувь нь 35-39 насныхан байна. Насны бүтцийг хүйсээр харвал, эрэгтэй, эмэгтэй ажиллагчдын дунд мөн 30-39, 50-54 насныхан зонхилж байгаа бөгөөд эрэгтэй ажиллагчдын 39.7 хувь нь 30-34 насныхан, 20.6 хувь нь 50-54 насныхан, эмэгтэй ажиллагчдын 32.6 хувь нь мөн 50-54 насныхан, 24.3 хувь нь 35-39 насны бүлгийн ажиллагчид байна. Ажиллагчдын дунд, 15-24 болон 55 ба түүнээс дээш насны эмэгтэйчүүд, 20-24 болон 60 ба түүнээс дээш насны эрэгтэй ажиллагч байхгүй байна.


Түүнчлэн 2024 оны эцэст усан хангамж, бохир ус зайлуулах систем, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагааны салбарын ажиллагчдын дунд 35-39 насныхан 2023 оныхоос 34.3 хувь, 50-54 насныхан 35.2 хувиар нэмэгдсэн бол 60-64 насныхан 3.6 дахин, 55-59 насныхан 3.0 дахин, 45-49 насны залуус 2.4 дахин буурсан байна.

Ажиллагчдын насны бүтцэд гарсан өөрчлөлт хүйсээр ялгаатай байна, тухайлбал, эрэгтэй ажиллагчид 2.0 дахин буурсны дотор 40-44 насныхан 3.6 дахин, 50-54 насныхан 3.4 дахин, 60-64 насныхан 3.3 дахин буурч, 45-49 насныхан 9.2 хувиар, 55-59 насныхан

4.1 хувиар нэмэгдсэн бол эмэгтэй ажиллагчид 5.4 хувиар буурсны дотор 45-49 насны эмэгтэйчүүд 4.6 дахин буурч харин 50-54 насныхан 2.2 дахин, 40-44 насныхан 2.0 дахин, 35-39 насныхан 1.8 дахин, 30-34 насны эмэгтэйчүүд 1.6 дахин нэмэгдсэн байна. Мөн 2023 онд энэ салбарт 15-19 насны эрэгтэй ажиллагч байхгүй байсан бол 2024 онд 19 хүн ажиллаж байна.


Усан хангамж, бохир ус зайлуулах систем, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагааны салбарын ажиллагчдын хүйсийн харьцааг авч үзвэл, 100 эрэгтэй ажиллагчдад 172 эмэгтэй ажилтан ногдож байна.

Зураг 19. Усан хангамж, бохир ус зайлуулах систем, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа салбарт ажиллагчдын тоо, насны бүлэг, хүйсээр, 2024




Усан хангамж, бохир ус зайлуулах систем, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагааны салбарын ажиллагчдыг газар зүйн байршлаар авч үзвэл, ажиллагчдын 43.6 хувь нь Улаанбаатар хотод, 23.0 хувь нь Хангайн бүсэд, 16.0 хувь нь Төвийн бүсэд ажиллаж байна. Ажиллагчдын тоог аймаг, нийслэлээр авч үзвэл, аймгуудаас Хөвсгөл аймаг (1150)-т хамгийн олон хүн энэ салбарт ажиллаж байна.

Газрын зураг 9. Усан хангамж, бохир ус зайлуулах систем, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагааны салбарт албан бус хөдөлмөр эрхлэгчид, бүсээр, 2024



Усан хангамж, бохир ус зайлуулах систем, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагааны салбарт 2024 онд 252 хүн албан бус хөдөлмөр эрхэлж байсан бөгөөд тэдний талаас илүү нь буюу 59.1 хувь нь эмэгтэйчүүд, 40.9 хувь нь эрэгтэйчүүд байна. Тус салбарт албан бус хөдөлмөр эрхлэгчид 2023 оноос 4.4 дахин буурсны дотор эрэгтэйчүүд 6.2 дахин, эмэгтэйчүүд 3.1 дахин тус тус буурсан байна.

Зураг 20. Усан хангамж, бохир ус зайлуулах систем, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагааны салбарт албан бус хөдөлмөр эрхлэгчид, хүйсээр, жил бүрийн эцэст



Усан хангамж, бохир ус зайлуулах систем, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагааны салбарт албан бус хөдөлмөр эрхлэгчдийн дийлэнх нь буюу 149 хүн Хөвсгөл аймагт, үлдсэн 103 хүн нь Завхан аймагт ажиллаж байна.

2024 онд гадаад улсад хөдөлмөрийн гэрээгээр ажиллахаар 4 иргэн зуучлагдсан бөгөөд 3 нь эмэгтэйчүүд байна. Хөдөлмөрийн гэрээгээр манай улсын усан хангамж, бохир ус зайлуулах систем, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагааны салбарт 2024 онд 1 гадаадын иргэн ажилласан байна.

II. АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ЭРЭЛТ, НИЙЛҮҮЛЭЛТ

2.1 Эрэлт, нийлүүлэлтийн өнөөгийн байдал

Энэ хэсэгт Ази, Номхон далайн бүс нутгийн болон Монгол Улсын барилга, дэд бүтцийн салбарын ажиллах хүчний эрэлт, нийлүүлэлтийн өнөөгийн байдал, ажиллах хүчний хомсдол үүссэн эсэх талаарх мэдээллийг оруулаа.

2.1.1 Ази, Номхон далайн бүсийн ерөнхий тойм

Ази-Номхон далайн бүс нутаг нь Япон, Австрали зэрэг хөгжингүй эдийн засагтай, Хятад, Энэтхэг зэрэг хөгжиж буй хүчирхэг орнууд, Зүүн өмнөд Ази, Номхон далайн арлуудыг хамарсан хөгжиж буй орнуудыг хамарсан дэлхийн хамгийн том хөдөлмөрийн зах зээлийн нэг юм.

Ази, Номхон далайн бүс нутагт хурдацтай хотжилт, засгийн газрын дэд бүтцийн хөрөнгө оруулалт, эдийн засгийн өсөлт зэргээс шалтгаалж барилга, дэд бүтцийн салбарт ажиллах хүчний хомсдол нэмэгдэж байна. Ажиллах хүчний эрэлт нэмэгдсээр байгаа хэдий ч нийлүүлэлтийн хязгаарлалт нь бодлого боловсруулагчид болон салбарын оролцогч талуудын хувьд нэн даруй анхаарал хандуулах шаардлагатай чухал сорилт болж байна.

Ази, Номхон далайн бүсийн барилгын зах зээл дэлхийн хэмжээнд хамгийн хурдацтай хөгжиж буй барилгын зах зээл болох нь гэсэн таамаглал байгаа бөгөөд 2024 онд тогтвортой өсөлт нь 3.3% байхаар төлөвтэй байна. Энэ өсөлт нь үндсэндээ дараахь хүчин зүйлээс шалтгаална. Үүнд:

- Дэд бүтцийн төслүүдэд оруулж буй Засгийн газрын хөрөнгө оруулалт
- Хотжилт, хүн амын хурдтай өсөлт
- Логистикийн дэд бүтэц шаардлагатай цахим худалдааны өргөжилт
- 5G сүлжээг нэвтрүүлэх, дижитал дэд бүтцийн хэрэгцээ
- Ногоон байгууламж, тогтвортой байдлын санаачлага.

Ази, Номхон далайн бүс нутаг болон Монгол Улс барилга, дэд бүтцийн салбарт ажиллах хүчний хомсдолд ихээхэн өртөж байна. Зүүн өмнөд Азийн бүс нутагт 2025 он гэхэд барилга, дэд бүтцийн хөгжлийн өсөлтийг хангахын тулд 1.5 сая мэргэжилтэй ажилтан шаардлагатай болно. Тухайлбал, Тайландын барилгын салбарт 400 мянга орчим ажилтан шаардлагатай болохоор байна[5]. Хонг Конгт 5 жилийн дотор 40,000 мэргэжилтэй ажилтан, 15,000 мэргэжилтэн дутагдах магадлалтай.

Ажиллах хүчний нийлүүлэлтийг хангахад Ази, Номхон далайн бүсийн хөгжингүй эдийн засагтай орнуудын хувьд ихэвчлэн гадагш чиглэсэн механизмыг ашиглаж байна. Тухайлбал, Япон улсын хувьд Хүн амын хүчтэй хөгшрөлт, төрөлт буурч байгаа сорилт тулгарч байгаа энэ үед эмэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцоог нэмэгдүүлэх бодлого хэрэгжүүлсний дүнд 1990 онд эмэгтэйчүүдийн ажиллах хүчний

[5] https://marketresearchthailand.com/insights/articles/how-to-tackle-thailand-construction-labor-market-shortages

оролцоо 48% байсан бол 2020 онд 71% хүрсэн байна. Түүнчлэн тэтгэвэрт гарах насны болон ахмадуудын хөдөлмөр эрхлэлтийн хөтөлбөрүүдийн хугацааг сунгах, гадаад ажилчдад зориулсан техникийн дадлагажигч бэлтгэх хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж, автоматжуулалт, робот техникийг өргөн ашиглах зэрэг механизмыг ашиглаж байна.

Австрали, Шинэ Зеланд зэрэг улсуудын хувьд, Ур чадварт суурилсан цагаачлал буюу мэргэшсэн ажилчдыг урьтал болгодог онооны систем, Номхон далайн арлын хөдөө аж ахуйд зориулсан улирлын чанартай ажилчдын хөтөлбөрүүд, залуу мэргэжилтнүүдэд зориулсан "ажиллан аялах" виз - залуучуудын хөдөлгөөнт хөтөлбөр (Youth mobility schemes), ажиллагчдыг орон нутагт хуваарилан ажиллуулах бүс нутгийн шилжилт хөдөлгөөний урамшуулал хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж байна.

БНСУ үйлдвэрлэлийн салбарт гадаадын ажилчид ажиллуулах үйлдвэрлэлийн дадлагажигч хөтөлбөр, 16 орноос ирж байгаа мэргэжлийн бус ажилчдад зориулсан E-9 визний систем, эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх "Төрөөс хөдөлмөр эрхэлж буй эхчүүдийг дэмжих санаачилга", инновацийн салбарт дэлхийн авьяастнуудыг татах технологийн салбарт анхаарал хандуулах хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж байна.

Дэлхийн хөгжиж буй томоохон эдийн засаг бүхий БНХАУ-ын хувьд хүн амын дотоод шилжих хөдөлгөөнтэй холбоотойгоор хөдөө аж ахуйн салбар дахь хөдөөгөөс хот руу чиглэсэн хөдөлмөрийн шилжилтийг удирддаг Хукоу систем, Дэлхийн хамгийн том үйлдвэрлэлийн хөдөлмөрийн түүхий эдийн нийлүүлэлтийг хангадаг боловсруулах үйлдвэрлэлийн ажиллах хүч, мэргэшил ур чадварыг дээшлүүлэх нийтийн мэргэжлийн боловсрол болон дээд боловсрол олголтыг өргөтгөх хөтөлбөр, хүн амын насжилт нэмэгдэж байгаа, нэг хүүхдийн бодлогыг зогсоох хүн ам зүйн шилжилтийн бодлого, дэлхийн хэмжээнд ажиллах хүч болон ур чадвар экспортлох "Бүс ба зам" үндэсний цогц санаачилга зэрэг механизмуудыг хэрэгжүүлж байна.

БНЭУ-ын хувьд, дэлхийн програм хангамж ба бизнесийн процессийн аутсорсинг төв болсон Мэдээллийн технологи, үйлчилгээний төв бодлого, маш олон тооны залуус ажиллах хүчинд орж байгаа – хүн ам зүйн ашиг, хэдэн зуун сая хүн хөдөө аж ахуйгаас ба үйлдвэрлэл, үйлчилгээний салбар руу шилжиж байгаа хөдөөгөөс хот руу шилжих урсгал, үндэсний болон мужийн түвшний мэргэжлийн боловсролын сургалтууд зохион байгуулах ур чадварын хөгжүүлэлт хөтөлбөр, дэлхий даяар өндөр ур чадвартай болон дунд боловсролтой ажилчдын том эх сурвалж болж гадаадад ажиллах хүч илгээх хөтөлбөр хэрэгжүүлж байна.

2.1.2 Монгол Улсын барилга, дэд бүтцийн салбарын ажиллах хүчний эрэлт нийлүүлэлт

Хөдөлмөрийн зах зээлд 2025 онд 83.7 мянган ажиллах хүчний эрэлт, хэрэгцээ бий болохоор байгаа нь өнгөрсөн жилийн ажиллах хүчний эрэлтээс 12.1 хувиар буурах төлөвтэй байна. Ажиллах хүчний эрэлтийн 79.2 хувь нь оны эхний хагаст, үлдсэн 20.8 хувь нь оны сүүлийн хагас жилд бий болох төлөвтэй байна. 2025 онд ажиллах хүчний эрэлт хамгийн их байх салбар нь өмнөх жилүүдийн адил бөөний болон жижиглэн

худалдаа, барилга, боловсруулах үйлдвэрлэлийн салбар бөгөөд хөдөлмөрийн зах зээлд гол эерэг нөлөөг үзүүлэх салбарууд хэвээр байна.

Ажиллах хүчний нийт эрэлтийн 15.0 хувь буюу 12.5 мянга нь барилгын салбарт бий болох төлөвтэй байна. Барилга болон боловсруулах үйлдвэрлэлийн салбарын ажиллах хүчний эрэлт өмнөхөөс буурах төлөвтэй бөгөөд харин бөөний болон жижиглэн худалдааны салбарын ажиллах хүчний эрэлт өсөх төлөвтэй байна.

Хүснэгт 4. 2025 онд шаардлагатай ажиллах хүчний эрэлт, салбараар

	Ажиллах хүчний эрэлт /мян.хүн/	Эхний хагас жил		Сүүлийн хагас жил	
		Тоо /мян.хүн/	Хувь	Тоо /мян.хүн/	Хувь
Цахилгаан, хий, уур, агааржуулалт	0.7	0.6	92.6	0.1	7.4
Барилга	12.5	11.4	91.4	1.1	8.6
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	3.5	2.8	79.0	0.7	21
Мэдээлэл, холбоо	2.0	1.7	85.2	0.3	14.8
Ус хангамж, сувагжилтын систем, хог хаягдал зайлуулах болон хүрээлэн буй орчныг дахин сэргээх үйл ажиллагаа	0.5	0.4	78.8	0.1	21.2

Эх үүсвэр: ХЗЗ-ийн эрэлтийн барометр судалгаа 2024

Оны эхний хагас жилд бий болохоор хүлээгдэж буй ажиллах хүчний эрэлтийн 58.2 мянга буюу 87.7 хувь нь байнгын ажлын байр бол 8.2 мянга нь түр ажлын байр байна. Эдийн засгийн үйл ажиллагааны салбар тус бүрээр авч үзвэл цахилгаан, хий, уур, агааржуулалт салбарын 92.6 хувь, барилгын салбарын ажиллах хүчний эрэлтийн 91.4 хувь оны эхний хагаст хамаарч байна.

Ажиллах хүчний сүүлийн хагас жилийн эрэлтийн хүрээнд бий болох ажлын байрны 69.5 хувь нь байнгын, үлдсэн хувь нь түр ажлын байр байна.

Хөдөлмөрийн зэх зээлд бий болох ажиллах хүчний эрэлтийг ажлын байрны хэлбэрээр дэлгэрүүлэн үзвэл 83.9 хувь буюу 70.2 мянга нь байнгын ажиллах хүчний эрэлт байна.

2025 оны 70.2 мянган байнгын ажиллах хүчний эрэлтийн 91.3 хувь буюу 64.1 мянга нь хувийн өмчийн ААНБ-уудад, 1.9 хувь буюу 1.3 мянга нь төрийн өмчийн, үлдсэн хувь нь хувийн хамтарсан, гадаад улсын хөрөнгө оруулалттай болон бусад өмчлөлийн хэлбэрийн ААНБ-д бий болохоор байна. Энэ удаад гадаадын хөрөнгө оруулалттай ААНБ-д бий болох эрэлт нь ажиллах хүчний нийт эрэлтэд эзлэх хувь нэмэгдсэн төдийгүй байнгын ажиллах хүчний эрэлтийн эзлэх хувь 1.4 пунктээр өсөх төлөвтэй байна.


Түр ажлын байрны хувьд ч 92.4 хувь нь хувийн өмчийн аж ахуйн нэгж байгууллагад бий болж үлдсэн хувь нь бусад өмчийн хэлбэрийн ажил олгогчдод бий болох төлөвтэй байна.

Байнгын ажиллах хүчний эрэлтэд гол нөлөө үзүүлж буй салбар нь бөөний болон жижиглэн худалдаа болон барилга, боловсруулах үйлдвэрлэлийн салбарууд бол түр

ажиллах хүчний эрэлтэд бөөний болон жижиглэн худалдаа болон барилгын салбараас гадна ХАА, ойн аж ахуй, загас барилт, ан агнуурын салбарын эрэлт гол хувийг эзэлж байна. Тухайн салбаруудын байнгын ажиллах хүчний эрэлт нийт байнгын ажлын байрны эрэлтийн 62.3 хувийг, түр ажиллах хүчний нийт эрэлтийн 70.1 хувийг тус тус бүрдүүлж байна.

Улсын хэмжээнд байнгын ажиллах хүчний эрэлтэд гол нөлөө үзүүлж буй салбар нь бөөний болон жижиглэн худалдаа, барилга, боловсруулах үйлдвэрлэлийн салбарууд бол түр ажиллах хүчний эрэлтэд ХАА, ойн аж ахуй, загас барилт, ан агнуурбн салбараас гадна бөөний болон жижиглэн худалдаа барилгын салбарын эрэлт мөн гол хувийг эзэлж байна. Тухайн салбаруудын байнгын ажиллах хүчний эрэлт нийт байнгын ажлын байрны эрэлтийн 62.3 хувийг, түр ажиллах хүчний нийт эрэлтийн 70.1 хувийг тус тус бүрдүүлж байна.


Зураг 21. 2025 онд шаардлагатай ажиллах хүчний эрэлт, ажлын байрны хэлбэр, салбараар



Эх үүсвэр: https://www.institute.gov.mn

Хөдөлмөрийн зах зээлийн нэг гол үзүүлэлт нь шинээр бий болох ажлын байр бөгөөд 2025 онд бий болох нийт ажиллах хүчний эрэлтийн 50.6 мянга буюу 60.4 хувь нь шинэ ажлын байранд ажилтан авах эрэлт байгаа нь хөдөлмөр эрхлэлт тухайн хэмжээгээр нэмэгдэх боломж буйг харуулж байна. Нийт эрэлтийн 33.1 мянга буюу 39.6 хувь нь сул ажлын байр байгаа нь нийт ажиллах хүчний эрэлтэд сул ажлын байрны эзлэх хувь хэмжээ өмнөх оныхоос 3.1 пунктээр өсөх үзүүлэлт болжээ.

Зураг 22. 2025 онд шаардлагатай ажиллах хүчний эрэлт, ажлын байрны төрлөөр, салбараар



Ажиллах хүчний эрэлтийн хүрээнд бий болох шинэ ажлын байрны 34.9 хувь нь бөөний болон жижиглэн худалдааны салбарт, 17.7 хувь нь барилгын салбарт, 7.7 хувь нь боловсруулах үйлдвэрлэлийн салбарт тус тус бий болох бол сул ажлын байрны ажиллах хүчний эрэлтийн 62.9 хувь нь мөн эдгээр салбаруудад бий болохоор харагдаж байна. Өөрөөр хэлбэл ирэх нэг жилд хөдөлмөрийн зах зээлд дээрх гурван салбар гол нөлөөг үзүүлэхээр байна.

Хэдийгээр нийт шинэ ажиллах хүчний эрэлтэд эзлэх шинэ ажлын байрны хувь буурсан ч барилгын салбарын шинэ ажиллах хүчний эрэлт 2.5 пунктээр өсөх төлөвтэй байна.

Ажиллах хүчний эрэлтийг ажил мэргэжлийн ангиллын үндсэн бүлгээр авч үзвэл ажиллах хүчний нийт эрэлтийн 19.7 хувийг мэргэжилтэн бүлгийн ажил мэргэжил, 15.0 хувийг менежер, 14.2 хувийг суурин төхөөрөмж, машин механизмын операторч, угсрагч, 9.3 хувийг үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил, үйлчилгээний ажилтан, 11.6 хувийг худалдаа, үйлчилгээний ажилтан бүлэгт хамаарах ажил мэргэжлийн эрэлт эзэлж, нийт ажиллах хүчний эрэлтийн 60.5 хувийг бүрдүүлж байна.

Эрэлтийг ажил мэргэжлийн хувьд авч үзвэл, барилга, дэд бүтцийн салбарын хувьд хүнд даацын автомашины операторч, барилга байгууламжийн, бүтээцийн технологийн инженер, цахилгааны инженер, засалчин, шаварчин, замын инженер гэх зэрэг 50 гаруй ажил мэргэжил эрэлттэй ажил мэргэжлийн хүрээнд нэрлэгдэж байна (Хавсралтаас дэлгэрэнгүйг харна уу).

Хүснэгт 5. Эрэлттэй ажил мэргэжил

№	Ажил, мэргэжил	Эрэлт, хүнээр	№	Ажил, мэргэжил	Эрэлт, хүнээр
1	Операторч, хүнд даацын автомашины	1722	14	Сантехникч, хоолой засварчин	395
2	Инженер, барилга байгууламжийн, бүтээцийн технологийн	1471	15	Дарга, мастер /менежер/, алба, хэлтэс, тасаг, цех, ээлжийн /барилга угсралтын/	394
3	Инженер, цахилгааны	1236	16	Инженер, замын	379
4	Барилга угсралтын мужаан	1119	17	Засалчин, шаварчин	298
5	Туслах ажилтан, барилга угсралтын	1037	18	Мэдээллийн технологийн менежер	286
6	Гагнуурчин	970	19	Зуухны машинист, засварчин	283
7	Шаварчин-засалчин, засал чимэглэлийн	853	20	Заслын мужаан	244
8	Интерьер архитекторч /дизайнер/	802	21	Техникч, ус хангамж, ариутгах татуургын	230
9	Барилгачин	646	22	Техникч, барилгын материалын үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж	220
10	Туслах ажилтан, барилгын туслах	488	23	Механикч, инженер, дулааны	208
11	Механикч, инженер, машин механизмын	481	24	Мужаан, засварын	174
12	Программ хангамжийн инженер	471	25	Архитекторч, барилгын /иргэний/	164
13	Ачигч, агуулахын	455	26	Инженер, хөдөлмөрийн аюулгүй байдлын	156

2023 онд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам (ХНХЯ), Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, үнэлгээ, судалгааны институт (ХНХСҮСИ) болон судалгаа зөвлөх үйлчилгээний Эм Эм Си Жи ХХК-ийн багтай хамтран гүйцэтгэсэн Монгол улсын хөдөлмөрийн зах зээлийн дунд хугацааны (2025-2035 он) эрэлт, нийлүүлэлтийн таамаглалын судалгааны үр дүнгээс харахад, барилгын салбарт шинээр шаардлагатай 82.8 мянган ажиллагчдаас 54.5 мянга нь барилга угсралт, 16.8 мянга нь барилгын тусгай үйл ажиллагаа, үлдсэн 10.9 мянга нь иргэний зориулалттай инженерийн байгууламжийн угсралтын үйл ажиллагааны салбарын ажиллагчид байна.

Хүснэгт 6. Эрэлттэй ажил мэргэжил

Салбар	Дэд салбар	2025	2035	Зөрүү
Цахилгаан, хий, уур, агааржуулалт	Цахилгаан, хий, уур, агааржуулалт	25.5	41.7	16.2
Усан хангамж, бохир ус зайлуулах систем, хог, хаягдлын менежмент	Ус цуглуулах, ариутгах, ус хангамж	6.7	7.0	0.3
	Бохир ус цуглуулах, цэвэршүүлэх, ариутгах үйл ажиллагаа	0.2	0.2	0
	Хог хаягдлыг цуглуулах, ариутгах, боловсруулах үйл ажиллагаа	1.8	1.8	0

	Хог, хаягдлын менежментийн бусад болон цэвэрлэх үйл ажиллагаа	0.7	0.8	0.1
Барилга	Барилга угсралт	69.7	124.2	54.5
	Иргэний зориулалттай инженерийн байгууламжийн угсралтын үйл ажил	13.9	24.7	10.9
	Барилгын тусгай үйл ажиллагаа	21.5	38.3	38.3
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	Хуурай замын болон хий дамжуулах хоолойн тээвэрлэлт	57.6	55.5	-2
	Усан замын тээвэр	0	0	0
	Агаарын тээвэр	5.9	5.7	-0.2
	Агуулахын болон тээврийн туслах үйл ажиллагаа	7.4	7.1	-0.3
	Шуудан, зарлага, элчийн үйл ажиллагаа	1.2	1.2	0
Мэдээлэл, холбоо	Эх бэлтгэх, нийтлэх үйл ажиллагаа	1.1	1.6	0.6
	Кино, видео, телевизийн хөтөлбөрийн үйлдвэрлэл, бичлэг хийх болон	0.6	0.9	0.3
	Өргөн нэвтрүүлэг бэлтгэх, дамжуулах үйл ажиллагаа	1.8	2.8	0.9
	Цахилгаан холбоо	16	24.1	8.1
	Компьютер программчлал, зөвлөгөө болон түүнд холбогдох үйл ажиллагаа	1.1	1.7	0.6
	Мэдээллээр үйлчлэх үйл ажиллагаа	0.7	1.1	0.4

Эх үүсвэр: http://institute.gov.mn/storage/sudalgaas/January2025/tcHvTgQnrim0sYHr2cGV.pdf

2025 онд хөдөлмөрийн зах зээлд бий болох нийт ажиллах хүчний эрэлтийг байршлаар тодруулбал, 60.2 хувь буюу 50.4 мянга нь Улаанбаатар хотод, 17.6 хувь буюу 14.7 мянга нь Хангайн бүсэд, 16.4 хувь буюу 13.7 мянга нь Төвийн бүсэд бий болох төлөвтэй байна.

2.2 Ажиллах хүчний хомсдол

Ази, Номхон далайн бүс нутагт эдийн засгийн сэргэлт харагдаж байгаа ч барилгын салбарт өргөн хүрээтэй ажиллах хүчний хомсдол үүсээд байна. Тус бүс нутагт ажилгүйдэл 2024 онд 4.2 хувь буюу 87.8 сая хүн ажилгүй байгаа нь 2025 онд хэвээр хадгалагдана гэж тооцоолсон нь Ази, Номхон далайн бүсийн хөдөлмөрийн зах зээл хүн ам зүйн сорилтуудын дунд сэргэж байгааг харуулж байна гэж Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллага мэдээлжээ. Гэвч энэхүү ажилгүйдлийн ерөнхий статистик нь салбарын дотоодын тэнцвэргүй байдлыг ялангуяа барилгын салбарт мэргэжлийн ур чадвартай ажиллах хүчний дутагдал бий болсон байгааг өнгөлөн далдалж байна.

Энэ байдал нь эдийн засгийн сэргэлттэй зэрэгцэн хүн ам зүйн сорилтууд тулгарч байгаагийн илрэл бөгөөд ирээдүйд хөдөлмөрийн зах зээлийн тогтворжилтанд нөлөөлж болзошгүй юм.

2.2.1 Ази, Номхон далайн бүсийн ерөнхий тойм

Ази, Номхон далайн бүс нутаг 2024 онд дэлхийд хамгийн хурдтай өсөх барилгын зах зээл болох төлөвтэй байгаа нь хөдөлмөрийн хүчний хомсдлын сорилтыг улам хурцатгаж байна. Азийн Номхон далайн бүс нутаг даяар барилгын салбарын ажиллах хүчний хомсдолд хэд хэдэн харилцан уялдаа бүхий хүчин зүйлс нөлөөлж байна:

- **Хүн ам зүйн сорилтууд:** Бүс нутгийн олон орон хүн амын насжилт болон төрөлт бууралтын асуудалтай тулгарч байгаа нь барилгын салбарт шинэ залуу ажиллах хүчний нөөцийг багасгаж байна.
- **Эдийн засгийн өсөлт ба хотжилт:** эдийн засгийн болон хотжилтын хурдтай хөгжил нь орон сууцнаас эхлээд томоохон дэд бүтцийн төслүүд хүртэл барилгын эрэлт хэрэгцээг урьд өмнө байгаагүй хэмжээнд нэмэгдүүлж байна.
- **Ур чадварын зөрүү:** Барилгын салбар нь ур чадвартай ажилчдын хомсдолд орж байгаа бөгөөд ялангуяа орчин үеийн барилгын хөгжиж буй технологийн эрэлт хэрэгцээг илэрхийлсэн эрчим хүчний хэмнэлт, дижиталжилт зэрэг тусгайлсан чиглэлүүдэд энэ асуудал илүү хурцаар мэдрэгдэж байна[6].
- **Барилгын материалын үнийн өсөлт:** Барилгын материалын үнийн өсөлт нь Зүүн Өмнөд Азийн улс орнуудын компаниуд зардлаа бууруулах шинэ арга замыг эрэлхийлж байгаа ч хөдөлмөрийн зардал мөн нэмэгдэж, барилгын төслүүдийг илүү үнэтэй болгож, зарим сегмент дэх ажилчдын эрэлтийг бууруулж болзошгүй байна[7].

Ази, Номхон далайн бүс нутгаас Зүүн Өмнөд Ази нь барилгын ажиллах хүчний хомсдолын хамгийн хурц тохиолдол бүхий хэсэг юм. Хотжилт, дэд бүтцийн хөрөнгө оруулалт, эдийн засгийн өсөлт нь Зүүн өмнөд Азийн барилгын салбарт хөдөлмөрийн асар их эрэлт хэрэгцээг бий болгож, ажиллах хүчний дутагдлын “төгс шуурга”-ыг бий болгож байна[8].

Бүс нутгийн барилга, бүтээн байгуулалтын өсөлтөд төрөөс зарцуулсан дэд бүтцийн зардал, гадаадын шууд хөрөнгө оруулалт, хотын хүн амын хурдацтай өсөлт зэрэг хэд хэдэн хүчин зүйл нөлөөлж байна. Гэсэн хэдий ч бэлэн байгаа ажиллах хүч нь энэхүү тэсрэх эрэлтийг гүйцэхгүй байна.

Ази, Номхон далайн бүс нутагт барилга, дэд бүтцийн ажиллах хүчний хомсдол нь засгийн газар, аж үйлдвэр, боловсролын байгууллагуудаас уялдаа холбоотой хариу арга хэмжээ авахыг шаардсан томоохон сорилт болж байна. Хэдийгээр асуудал хурцаар тавигдаж, ойрын хугацаанд улам бүр дордох төлөвтэй байгаа ч технологи нэвтрүүлэх, ажиллах хүчийг хөгжүүлэх, бүс нутгийн хамтын ажиллагаа зэрэг арга замаар урагшлах боломж бий.

Ялангуяа Монгол Улсын хувьд хөдөлмөрийн насны иргэд гадаадад хөдөлмөр эрхлэхээр олноороо явах нөхцөл байдал, дэд бүтцийн хөгжлийн томоохон төслүүд

[6] Our Mission 2024: Solutions for the Challenges of the Construction Industry | Crafthunt
[7] Rising Costs and Labour Shortages in Asia Cause Construction Sector to Seek Innovations - Asian Insiders
[8] Addresing Labor Market in Southeast Asia Construction

хэрэгжүүлэх төлөвлөгөө давхцаж байгаа нь тулгамдсан асуудлыг онцгой их хурцатгаж байна.

Ажиллах хүчний хомсдолтой тулгарсан эдгээр сорилтыг хамгийн үр дүнтэй шийдэж чадсан улс орон, бүс нутгууд хөгжлийн зорилгодоо амжилттайгаар хүрч хамгийн өрсөлдөх чадвартайгаар гарч ирэх бөгөөд шийдэж чадаагүй улсууд нь ажиллах хүчний хомсдолоос үүдэн эдийн засгийн өсөлт нь хязгаарлагдаж магадгүй юм.

2.2.2 Монгол Улсын ерөнхий тойм

2024 онд аж ахуйн нэгж байгууллагын 5.5 хувь нь шаардлагатай мэргэжилтэй ажилтан олдоогүйн улмаас төлөвлөсөн ажилтнаа авч чадаагүй буюу ажиллах хүчний хомсдолд өртсөн нь өмнөх оны мөн дүнгээс 18.1 пунктээр буурсан үзүүлэлт болжээ. Ажиллах хүчний хомсдолыг тархааж үзвэл ажиллах хүчний хомсдолд өртсөн нийт ААНБ-уудын 38.1 хувь нь бөөний болон жижиглэн худалдааны салбарт үйл ажиллагаа эрхэлж байгаа бөгөөд ажиллах хүчний хомсдолын 25.7 хувийг тухайн салбарын хомсдол эзэлж байна. Үүнээс гадна барилга, боловсруулах үйлдвэрлэлийн салбарын ажил олгогчид ажиллах хүчний хомсдолд өртсөн аж ахуйн нэгжүүдийн 21.4 хувийг эзэлж, эдгээр салбарын ажиллах хүчний хомсдол нийт 16.2 мянган ажлын байрны хомсдолын 44.3 хувийг бүрдүүлж байна. Үүнээс үзэхэд өнгөрсөн жил зөвхөн дээрх 3 салбаруудын хүрээнд ажиллах хүчний хомсдолоос үүдэлтэй 11.4 мянган ажлын байр сул байжээ. Харин уул уурхай, олборлолт, тээвэр, агуулахын үйл ажиллагааны салбар, санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа, урлаг, үзвэр, тоглоом наадам, үйлчилгээний бусад үйл ажиллагааны салбарын ажил олгогчид ажиллах хүчний хомсдолд өртсөн тохиолдлын эзлэх хувь хамгийн бага байна.

Хүснэгт 7. Ажиллах хүчний хомсдол, сонгосон салбараар

	Ажиллах хүчний хомсдол	
	Ажлын байрны тоо /мян/	Дүнд эзлэх хувь
Цахилгаан, хий, уур, агааржуулалт	0.6	1.2
Барилга	5.2	32.2
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	0.0	0.3
Мэдээлэл, холбоо	0.1	0.5
Ус хангамж, сувагжилтын систем, хог хаягдал зайлуулах болон хүрээлэн буй орчныг дахин сэргээх үйл ажиллагаа	0.2	1.0

Эх үүсвэр: ХЗЗ-ийн эрэлтийн барометр судалгаа 2024

Ажиллах хүчний хомсдолыг ажил мэргэжлийн бүлгийн хувьд авч үзвэл мэргэжилтэн, менежер, техникч болон туслах дэд мэргэжилтэн, үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил, үйлчилгээний ажилтан, энгийн ажил мэргэжлийн бүлгүүдийн ажил мэргэжлийн ажиллагчдын хомсдол 87.0 хувийг бүрдүүлж байгаа нь хамгийн өндөр үзүүлэлт болж байна.

Тухайн онд хомсдолтой байсан ажил мэргэжлийн хүрээн дэх ажиллах хүчний эрэлт хангагдаагүйгээс дараагийн оны ажиллах хүчний эрэлтэд ч мөн өндөр хувийг эзэлж байна. Тухайлбал, үйлдвэрлэл, аж ахуйн туслах ажилтан, барилгын туслах ажилтан, манаач болон засалчин, шаварчин, жолооч, хамгаалалтын албаны ажилтан, барилга угсралтын мужаан, төмөрлөгийн үйлдвэрийн мастер, цувигч, бусад ажилтан, тогооч, нягтлан бодогч, барилгын инженер, цахилгааны инженер зэрэг эрэлттэй ажил мэргэжлийн хүрээнд нэрлэгдсэн ажил мэргэжлүүдийн хүрээнд хомсдол буюу ажиллах хүчний дутагдал үүссэн байна.

Хүснэгт 8. Хомсдолтой 20 ажил мэргэжил, дүнд эзлэх хувь

д/д	Ажил мэргэжлийн нэр	Дүнд эзлэх хувь	д/д	Ажил мэргэжлийн нэр	Дүнд эзлэх хувь
1	Үйлдвэрлэл, аж ахуйн туслах ажилтан	15.0	11	Барилгачин	1.8
2	Даатгалын гэрээ байгуулагч	10.3	12	Хамгаалалтын/албаны ажилтан	1.7
3	Худалдааны төвийн менежер	9.9	13	Барилга байгууламжийн, бүтээцийн технологийн инженер	1.6
4	Засалчин, шаварчин	4.6	14	Тогооч	1.4
5	Барилга угсралтын мужаан	3.9	15	Төмөрлөгийн үйлдвэрийн мастер, цувигч, бусад ажилтан	1.4
6	Жолооч, хүн тээвэрлэх зориулалт бүхий хөдөлгүүрт хөсгийн	3.4	16	Манаач, сахиул, харуул, жижүүр	1.4
7	Мах махан бүтээгдэхүүний боловсруулах үйлдвэрлэлийн ажилтан	3.1	17	Нягтлан бодогч	1.3
8	Туслах ажилтан, барилгын туслах	2.8	18	Дарга, эрхлэгч / менежер/, алба, хэлтэс, тасгийн /борлуулалтын/	1.2
9	Цахилгааны инженер	2.1	19	Нарийн боов хийгч	1.1
10	Замын инженер	2.0	20	Жолооч, ачааны тэрэгний	1.1

Эх үүсвэр: ХЗЗ-ийн эрэлтийн барометр судалгаа 2024

Дурдагдсан ажил мэргэжлүүд /эхний 20 ажил мэргэжил/ ажиллах хүчний хомсдолд эзлэх хувийн жин 72.8 хувь байна. Энэ удаад дээд боловсролын хүрээнд бэлтгэгддэг ажиллагчдын дутагдал нийт хомсдолтой ажиллах хүчний хэмжээнд эзлэх хувийн жин өссөн байна. Онцлоход, менежер түвшний буюу удирдах албан тушаалын ажлын байранд үүссэн ажиллах хүчний дутагдал өмнөх оны дүнгээс багагүй хэмжээгээр өссөн байна.


Монгол Улсад 2035 он гэхэд томоохон дэд бүтцийн төслүүд болон бусад хөгжлийн ажлууд үргэлжлэх үед 240,000 орчим ажилчны дутагдал үүснэ гэж төсөөлж байна. Энэ нөхцөл байдал нь зөвхөн барилгын салбараас гадна эдийн засгийн олон салбарт нөлөөлж байгаа системийн асуудал юм.

Манай улсын барилга, дэд бүтцийн салбарт ажиллах хүчний хомсдол үүсэх дараах үндсэн шалтгаанууд байна гэж үзэж байна. Үүнд:

1. Хүн ам зүйн өөрчлөлт - Хүн амын насжилт нэмэгдэж, залуу ажилчдын тоо буурсан нь ажиллах хүчний нөөцийн бууралтад хүргэж байна. Энэ нь дэлхийн олон орны нийтлэг асуудал бөгөөд Монгол Улсад ч мөн адил нөлөөлж байна. Манай улсын хүн ам 2024 жилийн эцэст 3.5 сая болж, өмнөх оныхоос 40.1 мянгаар нэмэгдсэн бөгөөд нийт хүн амын 30.9 хувь нь 0-14 насны хүүхэд, 13.4 хувь нь 60 ба түүнээс дээш насныхан эзэлж байна.

Хүн амын насжилтыг харуулдаг нэг үзүүлэлт нь хүн ам зүйн ачаалал бөгөөд энэ нь хөдөлмөрийн насны 100 хүнд ногдох тэжээгдэгчийн тоог илэрхийлдэг. Хөдөлмөрийн насны 10 хүн тутамд 6 тэжээлгэгч ногдож байгаа бөгөөд эдгээрийн 5 нь 0-14 насны хүүхдүүд байна.

Зураг 23. Хүн ам зүйн ачаалал, хүнээр, 2020-2024



2. Монгол Улсын иргэд гадаад улсад ажиллах хандлага – иргэд гадаад оронд ажиллаж суурьших урсгал нь ажиллах хүчний хомсдлыг улам бүр хурцатгаж байна. Энэ нь илүү өндөр цалин, ажлын сайн нөхцөл эрэлхийлэгчдийг татаж байгаатай холбоотой.

3. Мэргэшсэн ажилчдын хомсдол - Барилгын болон дэд бүтцийн салбарт шаардлагатай техникийн ур чадвар, мэргэшсэн ажилчдын бэлтгэл сургалтын тогтолцоо, хүрэлцээ нь хомсдол үүсэх томоохон хүчин зүйл болж байна. 2024-2025 оны хичээлийн жилд нийт 40.9 мянган оюутан суралцаж байгаагийн 52.7 хувь буюу 21.5 мянга нь инженерчлэл, үйлдвэрлэл, дэд бүтэц, барилга байгууламжийн холбогдох мэргэжлээр, 3.1 хувь нь буюу 1.3 мянга нь мэдээлэл, харилцаа холбооны мэргэжлээр суралцаж байна.


4. Ажлын нөхцөлийн асуудал - барилгын ажил нь хүнд, цаг агаарын нөхцөлөөс шууд хамаардаг, улирлын шинжтэй, жилийн туршид тогтвортой орлого олдоггүй онцлогоос бас хамаарч байх талтай.

5. Цалин, урамшууллын асуудал - Барилгын салбарын цалингийн түвшин бусад салбартай харьцуулахад харьцангуй бага байгаа нь залуу ажилчдыг татахад саад болж байна.

Барилгын салбарын нэг ажилтны сарын дундаж нэрлэсэн цалин 2024 онд 2.2 сая төгрөг байсан нь улсын дундажаас 165.5 мянган төгрөгөөр бага байгаа бөгөөд ус хангамж; бохир ус зайлуулах систем, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагааны салбарт ажиллаж байгаа нэг ажилтны цалин улсын дундаж цалингаас 230.6 мянгаар доогуур байна. Мэдээлэл, холбоо, тээвэр ба агуулахын үйл ажиллагаа болон цахилгаан, хий, агааржуулалтын салбаруудын нэг ажилтны сарын дундаж нэрлэсэн цалин улсын дундаж цалингаас 135.4-591.3 мянгаар дээгүүр байна.

Түүнчлэн сүүлийн 5 жилийн хугацаанд, нэг ажилтны сарын улсын дундаж нэрлэсэн цалин 2024 онд 2020 оныхоос 1.9 дахин өссөн бол дэд бүтцийн салбарууд 1.7-2.2 дахин нэмэгдсэн байна.

Зураг 24. Нэг ажилтны сарын дундаж нэрлэсэн цалин, мянган төгрөгөөр, сонгосон салбараар, 2020, 2024



6. Боловсролын системийн дутагдал - техникийн болон мэргэжлийн боловсролын сургуулиудын суралцагчид, сурч буй мэргэжил нь шаардлагатай ур чадвартай ажилчин бэлтгэх гол суурь бөгөөд эрэлтэд нийцээгүй, шаардлагатай мэргэжилтэн дутагдалтай байх нь хүндрэл учруулна. Манай улсын хувьд их дээд сургууль, мэргэжлийн боловсролын сургуулиудад мэргэжилтэн бэлтгэж байна.

2023-2024 оны хичээлийн жилд 847 төгсөгч барилгын мэргэжлээр их, дээд сургууль төгссөний 368 нь барилгын инженерээр төгсчээ.

Зураг 25. 2023-2024 хичээлийн жилд их, дээд сургууль барилгын мэргэжлээр төгсөгчид




Дараах мэргэжлүүд барилгын салбарт эрэлттэй байна. Үүнд:

1. Барилгын инженер
2. Архитектор
3. Цахилгааны инженер
4. Ус, дулаан хангамжийн инженер
5. Барилгын менежер
6. Зам, гүүрний инженер
7. BIM (Building Information Modeling) мэргэжилтэн
8. Барилгын хяналтын мэргэжилтэн
9. Ногоон барилгын зөвлөх

БШУЯ-наас зохион байгуулсан 2022-2023 оны төгсөгчдийн мөшгөх судалгаагаар барилгын мэргэжлээр техникийн болон мэргэжлийн боловсрол эзэмшсэн **3974** төгсөгчөөс **2229** нь ажлын байртай болсон байна. Эдгээр төгсөгчдийн дийлэнх нь мэргэжлийн боловсрол эзэмшсэн байна.

Зураг 26. 2023-2024 хичээлийн жилд барилгын мэргэжлээр МСҮТ төгсөгчид



Улсын хэмжээнд 2024 онд ажил хайгч 36.4 мянган иргэн байсны 86.4 хувь нь бүрэн дунд ба түүнээс дээш боловсролтой байгаа бөгөөд ажил хайгч 10 хүн тутмын 6 нь бүрэн дунд боловсролтой, 3 нь дипломын болон бакалаврын дээд боловсролтой иргэд байна.

2024 оны байдлаар 85.4 мянган иргэн ажилгүй байгаа бөгөөд 2023 оныхоос 1.8 дахин нэмэгдсэн байна. Ажилгүй байгаа иргэдийн 34.3 хувь нь ажил хайгаад олдохгүй байгаа, 10.9 хувь нь мэргэжил, дадлага туршлага байхгүй, 9.1 хувь нь мэргэжилд тохирох ажил олдохгүй байгаа гэсэн бол 11.2 хувь нь хүүхэд, өндөр настан, өвчтөн асардаг учир ажилгүй байгаа гэсэн шалтгаан хэлсэн байна.

Ажиллах хүчнээс гадуурх хүн ам гэж сургуульд суралцаж байгаа, гэрийн ажилтай, өндөр настан, өндөр насны тэтгэвэр тогтоолгосон, хөгжлийн бэрхшээлтэй болон ажил хайх итгэл алдарсан зэрэг шалтгаанаар тухайн хугацаанд ажиллах хүчинд хамаарахгүй хөдөлмөрийн насны хүн ам бөгөөд 2024 оны эцэст ажиллах хүчнээс гадуурх 911.7 мянган хүн байна. Ажиллах хүчнээс гадуурх хүн амыг шалтгаанаар харвал 83.7 хувь нь суралцдаг, сурахаар явж байгаа (35.5%), тэтгэвэрт гарсан, өндөр настан (34.9%), Жирэмсэн/хүүхэд асарсан (13.2%) гэсэн шалтгаантай байна.

Монгол Улсын барилга, дэд бүтцийн салбар дахь ажиллах хүчний хомсдол нь олон хүчин зүйлээс хамаарч байгаа эдгээр асуудлыг шийдвэрлэхийн тулд цогц бодлого боловсруулж, хүний нөөцийн хөгжил, мэргэжлийн сургалт, ажлын нөхцөлийг сайжруулах, цалингийн түвшинг нэмэгдүүлэх зэрэг арга хэмжээ авах шаардлагатай байна.

III. БОДЛОГЫН ЗӨВЛӨМЖ

3.1 Боломж

Улаанбаатар хотын гэр хорооллыг дахин төлөвлөж, орон сууцжуулах бодлого, Монгол Улсын засгаас хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа мега төслүүд нь барилга, дэд бүтцийн салбарын ажилчдын эрэлтийг нэмэгдүүлж байна.

Хөдөлмөр эрхлэлтийн бодлогыг өнөөгийн нөхцөл байдалд тохируулан шинэчлэх, ажилгүй иргэд, ажил хайгч иргэдийн олонх нь ажил хайгаад олдохгүй байгаа, мэргэжил, дадлага туршлага байхгүй, мэргэжилд тохирох ажил олдохгүй гэсэн шалтгаануудыг хэлж байгаа бөгөөд эдгээр хүмүүсийг ажлын байраар хангаж хөдөлмөрийн зах зээлд оруулах нь ажилах хүчний хомсдолыг багасгах нэг боломж юм.

Их дээд сургуулийн болон мэргэжлийн болон техникийн боловсрол олгож байгаа мэргэжлийн чиглэлийг зах зээлийн өнөөгийн эрэлттэй уялдуулах, мөн дөвтөн сургах, нэг мэргэжлээс эрэлт ихтэй нөгөө мэргэжил рүү хөрвүүлэн сургах замаар хэрэгцээт хүний нөөцийг бүрдүүлэх боломж гарч болох юм. Ажиллагчдыг сургах, мэргэшүүлэх, давтан сургах асуудал ч мөн нэг гарц юм.

3.2 Бодлогын зөвлөмж

1. **Техникийн болон мэргэжлийн сургалтыг бэхжүүлэх:**
   - Барилгын коллеж, техникийн сургуулиудын хөтөлбөрийг өргөтгөх
   - Сургалтын хөтөлбөрийг орчин үеийн технологи, арга техникийн дагуу шинэчлэх
   - Дадлагажуулах, давтан сургах, хөрвүүлэн сургах хөтөлбөрийг боловсруулах
   - Багш нарын чадварыг дээшлүүлэх
   - Судалгаа, шинжилгээний төв байгуулах

2. Цалин хөлсийг нэмэгдүүлэх:
   - Барилга, дэд бүтцийн ажилчдын хөдөлмөрийн хөлсийн доод хэмжээг бодитой тогтоох
   - Ажлын гүйцэтгэлд суурилсан урамшуулалын систем бий болгох
   - Төслийн амжилтаар урамшуулах механизм
   - Эрүүл мэндийн даатгалын хамрах хүрээг өргөтгөх
   - Осол гэмтлийн даатгалыг бүрэн хангах
   - Тэтгэврийн сангийн оролцоог нэмэгдүүлэх

3. Ажлын нөхцөл, аюулгүй байдал, аюулгүй байдлын стандарт:
   - Ажлын байрны аюулгүй ажиллагааны дүрэм журмыг боловсронгуй болгох
   - Хамгаалалтын хэрэгслийг бүрэн хангах
   - Ажлын аюулгүй байдлын сургалтыг заавал зохион байгуулах
   - Орчин үеийн техник хэрэгслээр хангах, хиймэл оюун ухаан ашиглах

4. Ур чадварын хөгжил:

- Мэргэжлийн ур чадварыг үргэлжлүүлэн дээшлүүлэх сургалт
- Олон улсын гэрчилгээ авах боломжийг бүрдүүлэх
- Мэргэжлийн холбоодын үүрэг оролцоог нэмэгдүүлэх
- Мэргэжлийн сургалтын төвүүдийг дэмжих, ажилтныг чадавхжуулах, давтан сургах, мэргэшүүлэх
- Гадаад технологи, туршлагыг судлах, нэвтрүүлэх хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх

5. Хөдөлмөр эрхлэлтийн бодлогыг улам боловсронгуй болгох

- Хөдөлмөрийн зах зээлийн хэрэгцээний дагуу гадаадын мэргэжилтэн татах
- Ур чадвар шилжүүлэх хөтөлбөр хэрэгжүүлэх
- Орон нутгийн ажиллах хүчинтэй хамтран ажиллах арга замыг бүрдүүлэх
- Эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх
- Тэгш боломжийн бодлого хэрэгжүүлэх

6. Санхүүжилт, дэмжлэг

- Оюутан, суралцагчдад тэтгэлэг олгох хөтөлбөр
- Мэргэжилтэй ажилтан бэлтгэхэд дэмжлэг үзүүлэх
- Хувийн хэвшлийн том компаниудад дадлагын байр бий болгохыг төрөөс дэмжих
- Мэнтор, зөвлөх хөтөлбөр хэрэгжүүлэх

ХАВСРАЛТ

Эрэлттэй мэргэжлийн жагсаалт

№	Ажил, мэргэжил	Эрэлт, хүнээр
1	Операторч, хүнд даацын автомашины	1722
2	Инженер, барилга байгууламжийн, бүтээцийн технологийн	1471
3	Инженер, цахилгааны	1236
4	Барилга угсралтын мужаан	1119
5	Туслах ажилтан, барилга угсралтын	1037
6	Гагнуурчин	970
7	Шаварчин-засалчин, засал чимэглэлийн	853
8	Интерьер архитекторч /дизайнер/	802
9	Барилгачин	646
10	Туслах ажилтан, барилгын туслах	488
11	Механикч, инженер, машин механизмын	481
12	Программ хангамжийн инженер	471
13	Ачигч, агуулахын	455
14	Сантехникч, хоолой засварчин	395
15	Дарга, мастер /менежер/, алба, хэлтэс, тасаг, цех, ээлжийн /барилга угсралтын/	394
16	Инженер, замын	379
17	Засалчин, шаварчин	298
18	Мэдээллийн технологийн менежер	286
19	Зуухны машинист, засварчин	283
20	Заслын мужаан	244
21	Техникч, ус хангамж, ариутгах татуургын	230
22	Техникч, барилгын материалын үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж	220
23	Механикч, инженер, дулааны	208
24	Мужаан, засварын	174
25	Архитекторч, барилгын /иргэний/	164
26	Инженер, хөдөлмөрийн аюулгүй байдлын	156
27	Агуулахын ажилтан	141
28	Слесарь, металл хийц угсралтын	140
29	Инженер, барилгын менежментийн	129
30	Менежер, ачаа тээврийн	126
31	Газар шороо, зам засварын болон түүнтэй адилтгах машины операторч	120

32	Архитекторч, барилгын /үйлдвэрийн/	100
33	Технологич, барилгын материалын	99
34	Механикч, дулааны тоног төхөөрөмжийн, цахилгаан угсралтын, цахилгаан тоног төхөөрөмжийн, зөөврийн цахилгаан станцын	84
35	Инженер, иргэний ба үйлдвэрийн барилгын	57
36	Техникч, барилга угсралтын	55
37	Туслах ажилтан, автозамын	49
38	Өрөгч, угсрагч, барилгын	45
39	Техникч, төмөр замын, зүтгүүрийн	44
40	Замчин, төмөр замын	39
41	Технологич, инженерийн /иргэний барилгын/	39
42	Инженер, ус хангамж, ариутгах татуургын	24
43	Засварчин, өргөн тээвэрлэх тоног төхөөрөмжийн	24
44	Монтёр цахилгааны /хот хоорондын холбооны шугамын/	19
45	Инженер, барилгын материал үйлдвэрлэлийн автоматжуулалтын	10
46	Сантехникч, технологийн дамжуулах хоолойн эд анги, зангилааг бэлтгэх	9
47	Инженер, цахим зүйн /цахилгаан холбооны/	6
48	Маркшейдер /зурагзүйч/	6
49	Гагнуурчин, цахилгаан ба хийн	6
50	Инженер, хяналтын	6
51	Инженер, цахилгаан автоматикийн	4
52	Техникч, төмөр замын, вагоны	3
53	Операторч, токарийн суурь машины /токарьчин/	3
54	Цахилгаанчин	2
55	Операторч, усан цахилгаан станцын эрчим хүчний төхөөрөмжийн	2
56	Геологич, инженер	2
57	Инженер, халаалт, агаар сэлгэлт, агааржуулалтын	1
58	Техникч, халаалт, агаар сэлгэлтийн	1
59	Мэдээлэл, холбооны технологи боловсруулах менежер	1

АШИГЛАСАН МАТЕРИАЛУУД

1. www.1212.mn
2. https://www.nso.mn/uploads/cdcM_bx5vLPX9B0G9c5IdmrlPb-l6wlKuj8NJAXB.pdf
3. https://www.nso.mn/uploads/fDarad-e-OBL-GXiv-BxdD-vyxkfZ6tCmZ-9bgHh.pdf
4. https://www.nso.mn/uploads/SUpK64X_I7PIyc_J71bOKOctnI-zBx-B0QOq2zCG.pdf
5. https://moe.gov.mn/statistics-industry?category_id=11397
6. https://moe.gov.mn/statistics-industry?category_id=14859
7. https://moe.gov.mn/statistics-industry?category_id=11403
8. https://moe.gov.mn/post/157128 Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллага төгсөгчийн хөдөлмөр эрхлэлтийн “мөшгөх судалгаа”-ны тайлан /2022-2023 оны хичээлийн жилийн төгсөгч/
9. https://mlsp.gov.mn/content/detail/950 Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийн барометрийн судалгаа
10. http://institute.gov.mn/storage/sudalgaas/October2024/6NpGHZgyBgNkXbfRfb4L.pdf
11. www.ilo.org
12. www.worldbank.org
13. https://www.arcadis.com/ What are the key issues facing construction in Asia in 2023?
14. https://www.marketresearchsoutheastasia.com/Addresing Labor Market in Southeast Asia Construction
15. Inquirer Business https://www.inquirer.net/ Shortage of skilled workers still hounds gov’t infrastructure plans